

ИХЭР МӨРӨН АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Титэм сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/195/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tэгshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
УИХ	Улсын их хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/115
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Титэм сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Титэм сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгө данс 74,035.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалын дагуу тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлаар компьютер, техник хэрэгсэл худалдаж авахаар төлбөр хийсэн боловч тайлант хугацаанд нийлүүлэгдээгүйгээс 100,835.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Сургуулийн захирал Мөрөн сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг төлөвлөж, 84.1 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын

стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А. ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	163,194,648.98	372,780,025.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	74,035,476.58
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	74,035,476.58
31210	Төгрөг	-	74,035,476.58
31211	Төрийн сангийн харилцах	-	74,035,476.58
33	АВЛАГА	-	102,086,763.72
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	726,476.85
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	516,000.00
33500	Бусад авлага	-	100,844,286.87
33510	Байгууллагаас авах авлага	-	100,835,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	9,286.87
34	УРЬДЧИЛГАА	-	3,480,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	3,480,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	163,194,648.98	193,177,785.58
35100	Түүхий эд материал	2,124,500.00	2,124,500.00
35130	Эм боох материал	2,124,500.00	2,124,500.00
35400	Хангамжийн материал	161,070,148.98	191,053,285.58
35420	Аж ахуйн материал	18,789,410.60	15,660,373.00
35470	Бусад хангамжийн материал	142,280,738.38	175,392,912.58
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,863,714,896.21	2,685,167,463.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,863,714,896.21	2,685,167,463.32
39200	Биет хөрөнгө	2,415,239,896.21	2,236,877,463.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,100,329,204.00	2,100,329,204.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(178,066,280.60)	(255,006,180.32)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	369,087,242.38	432,120,163.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	(87,217,314.58)	(244,812,733.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	126,727,633.50	141,061,718.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,950,088.13)	(51,632,910.38)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	15,000,000.00	15,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	51,309,036.00	51,309,036.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,138,880.19)	(20,181,455.15)
39217	Ном	66,159,343.83	68,690,621.33
39300	Биет бус хөрөнгө	448,475,000.00	448,290,000.08
39301	Програм хангамж	925,000.00	925,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(184,999.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	447,550,000.00	447,550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,026,909,545.19	3,057,947,489.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	0.09
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	0.09
41300	Өглөг	-	0.09
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	0.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,026,909,545.19	3,057,947,489.11
51	Засгийн газрын хувь оролцоо	3,026,909,545.19	3,057,947,489.11
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,211,897,505.67	1,211,897,505.67
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,211,897,505.67	1,211,897,505.67
51200	Хуримтлагдсан үр дүн	1,370,891,799.90	1,401,929,743.82
51210	Өмнөх үеийн үр дүн	1,216,452,041.31	1,371,498,466.61
51220	Тайлант үеийн үр дүн	154,439,758.59	30,431,277.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	444,120,239.62	444,120,239.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,026,909,545.19	3,057,947,489.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,298,873,971.05	2,888,197,695.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	272,884,724.05	153,959,695.00
120	Нийтлэг татварын бус орлого	272,884,724.05	139,649,695.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	11,341,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	11,271,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	263,625,118.80	107,239,923.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,259,605.25	21,068,272.00
122	Тусламжийн орлого	-	14,310,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	14,310,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,025,989,247.00	2,734,238,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,701,104,000.00	2,376,247,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,376,247,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,701,104,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,045,247.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,050,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,925,247.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	309,840,000.00	357,990,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	309,840,000.00	357,990,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,129,136,780.46	2,843,755,004.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,129,136,780.46	2,843,755,004.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,053,705,934.62	2,598,929,499.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,394,575,642.00	1,688,437,662.90
210101	Үндсэн цалин	1,171,700,146.00	1,205,203,358.30
210102	Нэмэгдэл	149,576,793.00	375,952,895.60
210104	Урамшуулал	73,298,703.00	107,281,409.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,216,629.62	213,095,442.02
210201	Тэтгэврийн даатгал	127,789,559.32	145,903,862.59
210202	Тэтгэмжийн даатгал	14,362,182.35	17,183,163.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,229,792.63	13,696,130.65
210204	Ажилгүйдлийн даатгал	2,712,281.35	3,298,958.53
210205	Эрүүл мэндийн даатгал	27,122,813.97	33,013,326.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	297,796,224.54	304,852,256.52
210301	Гэрэл, цахилгаан	4,350,554.00	7,147,425.00
210302	Түлш, халаалт	286,755,628.09	286,755,626.52
210303	Цэвэр, бохир ус	6,690,042.45	10,949,205.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,269,202.00	17,504,347.60
210401	Бичиг хэрэг	2,269,120.00	148,000.00
210402	Тээвэр, шатахуун	263,952.00	1,020,130.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,339,917.00	524,590.00
210404	Ном, хэвлэл	136,200.00	191,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,055,760.00	607,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,204,253.00	15,012,127.60
2105	Нормативт зардал	2,259,630.00	1,632,849.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,259,630.00	708,849.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	924,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,713,880.00	18,651,700.00
210604	Урсгал засвар	11,713,880.00	18,651,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,243,250.00	510,000.00
210702	Дотоод албан томилолт	1,243,250.00	510,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,825,307.00	35,004,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,817,307.00	25,073,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,923,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,806,169.46	319,240,641.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	17,564,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,742,916.00	15,983,431.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	124,063,253.46	285,692,609.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,430,845.84	244,825,505.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,922,100.00	243,422,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,622,100.00	188,754,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	54,668,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	139,895.46	1,403,005.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	139,895.46	1,403,005.35
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,368,850.38	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,368,850.38	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	169,737,190.59	44,442,690.41
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,297,432.00	14,011,413.20
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	7,871,077.70
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	15,297,432.00	6,140,335.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	154,439,758.59	30,431,277.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,031,602,247.00	2,745,063,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	10,825,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	10,825,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	10,825,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,755,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,031,602,247.00	2,734,238,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,701,104,000.00	2,376,247,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,376,247,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,701,104,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,658,247.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,050,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,925,247.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,683,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	309,840,000.00	357,990,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	309,840,000.00	357,990,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,005,931,148.00	2,671,028,023.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,005,931,148.00	2,671,028,023.42

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,930,500,302.16	2,426,202,518.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,394,575,642.00	1,689,173,426.53
210101	Үндсэн цалин	952,140,577.58	1,285,616,980.93
210102	Нэмэгдэл	369,136,361.42	312,740,427.60
210104	Урамшуулал	73,298,703.00	90,816,018.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,216,629.62	213,095,442.02
210201	Тэтгэврийн даатгал	128,722,593.54	145,983,206.71
210202	Тэтгэмжийн даатгал	13,653,258.85	17,372,866.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,925,325.89	13,582,452.57
210204	Ажилгүйдлийн даатгал	3,095,212.00	3,284,797.88
210205	Эрүүл мэндийн даатгал	26,820,239.34	32,872,118.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	297,796,224.54	304,852,256.52
210301	Гэрэл, цахилгаан	4,350,554.00	7,147,425.00
210302	Түлш, халаалт	286,755,628.09	286,755,626.52
210303	Цэвэр, бохир ус	6,690,042.45	10,949,205.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,278,539.00	-
210401	Бичиг хэрэг	2,269,120.00	-
210402	Тээвэр, шатахуун	263,952.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,339,917.00	-
210404	Ном, хэвлэл	5,749,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,055,760.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,600,590.00	-
2105	Нормативт зардал	1,326,330.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	726,330.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,903,880.00	16,117,000.00
210604	Урсгал засвар	11,903,880.00	16,117,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,243,250.00	-
210702	Дотоод албан томилолт	1,243,250.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,545,307.00	19,678,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,537,307.00	10,755,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,923,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,614,500.00	183,285,693.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	151,746,193.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,614,500.00	31,539,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,430,845.84	244,825,505.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,922,100.00	243,422,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,622,100.00	188,754,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	54,668,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	139,895.46	1,403,005.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	139,895.46	1,403,005.35
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,368,850.38	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,368,850.38	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	25,671,099.00	74,035,476.58
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	25,671,099.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,671,099.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	25,671,099.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,671,099.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(25,671,099.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	74,035,476.58

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	74,035,476.58

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,211,897,505.67	447,714,632.41	1,212,857,648.52	2,872,469,786.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,594,392.79	3,594,392.79
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,211,897,505.67	447,714,632.41	1,216,452,041.31	2,876,064,179.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-3,594,392.79	-	-3,594,392.79
Тайлант үеийн үр дүн	-	-	154,439,758.59	154,439,758.59
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,211,897,505.67	444,120,239.62	1,370,891,799.90	3,026,909,545.19
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,211,897,505.67	444,120,239.62	1,370,891,799.90	3,026,909,545.19
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,211,897,505.67	444,120,239.62	1,370,891,799.90	3,026,909,545.19
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	606,666.71	606,666.71
Тайлант үеийн үр дүн	-	-	30,431,277.21	30,431,277.21
2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,211,897,505.67	444,120,239.62	1,401,929,743.82	3,057,947,489.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,387,249,500.00	2,313,037,823.42	74,176,676.58	96.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,387,249,500.00	2,313,037,823.42	74,176,676.58	96.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,138,843,500.00	2,069,615,323.42	69,193,176.58	96.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,685,963,800.00	1,657,431,888.40	28,531,911.60	98.31
210101	Үндсэн цалин	1,189,410,800.00	1,257,623,374.80	-68,212,574.80	105.73
210102	Нэмэгдэл	426,479,800.00	310,599,952.60	115,879,847.40	72.83
210104	Урамшуулал	70,073,200.00	89,208,561.00	-19,135,361.00	127.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,745,500.00	209,219,042.02	1,526,457.98	99.28
210201	Тэтгэврийн даатгал	143,306,900.00	143,347,206.71	-40,306.71	100.03
210202	Тэтгэмжийн даатгал	16,859,600.00	17,062,866.27	-203,266.27	101.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,487,700.00	13,334,452.57	153,247.43	98.86
210204	Ажилгүйдлийн даатгал	3,372,000.00	3,222,797.88	149,202.12	95.58
210205	Эрүүл мэндийн даатгал	33,719,300.00	32,251,718.59	1,467,581.41	95.65
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,993,000.00	19,678,700.00	12,314,300.00	61.51

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Титэм сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,966,700.00	10,755,500.00	211,200.00	98.07
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,026,300.00	8,923,200.00	12,103,100.00	42.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	210,141,200.00	183,285,693.00	26,820,507.00	87.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	178,601,700.00	151,749,193.00	26,817,507.00	84.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,539,500.00	31,539,500.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	248,406,000.00	243,422,500.00	4,983,500.00	97.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	248,406,000.00	243,422,500.00	4,983,500.00	97.99
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	193,737,500.00	188,754,000.00	4,983,500.00	97.43
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,668,500.00	54,668,500.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,387,249,500.00	2,387,073,300.00	141,200.00	99.99
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,376,247,800.00	2,376,247,800.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,376,247,800.00	2,376,247,800.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,001,700.00	10,825,500.00	141,200.00	98.71
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,966,700.00	10,755,500.00	211,200.00	98.07
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	70,000.00	-70,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	74,035,476.58	-74,035,476.58	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	108	108	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	94	94	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	13	13	-	100.00

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Орон нутгийн төсвийн		/төгрөгөөр/	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	357,990,200.00	356,587,194.65	1,403,005.35	99.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357,990,200.00	356,587,194.65	1,403,005.35	99.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,990,200.00	356,587,194.65	1,403,005.35	99.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,741,700.00	31,741,538.13	161.87	100.00
210101	Үндсэн цалин	27,993,700.00	27,993,606.13	93.87	100.00
210102	Нэмэгдэл	2,140,500.00	2,140,475.00	25.00	100.00
210104	Урамшуулал	1,607,500.00	1,607,457.00	43.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,876,400.00	3,876,400.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	2,636,000.00	2,636,000.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	310,000.00	310,000.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	248,000.00	248,000.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	62,000.00	62,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	620,400.00	620,400.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	306,255,100.00	304,852,256.52	1,402,843.48	99.54

210301	Гэрэл, цахилгаан	8,500,000.00	7,147,425.00	1,352,575.00	84.09
210302	Түлш, халаалт	286,755,100.00	286,755,626.52	-526.52	100.00
210303	Цэвэр, бохир ус	11,000,000.00	10,949,205.00	50,795.00	99.54
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,117,000.00	16,117,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	16,117,000.00	16,117,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	357,990,200.00	356,587,194.65	1,403,005.35	99.61
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	357,990,200.00	356,587,194.65	1,403,005.35	99.61
132001	Орон нутгийн төсвөөс	357,990,200.00	356,587,194.65	1,403,005.35	99.61

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

1.6.1 Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хөвсгөл аймгийн Титэм ерөнхий боловсролын сургууль нь бага болон суурь, дунд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол Шинжлэх Ухааны Яамны харьяа байгууллага юм.

Сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

2022 онд “Багш бүр сургалтын чанарыг бодитой үнэлэх арга зүйд суралцан, сурлагын хоцрогдлыг бууруулж сурагчдыг адил тэгш суралцах боломжоор хангана” гэсэн зорилго тавьж ажилласан ба энэхүү зорилгын хүрээнд багш, сургууль, суралцагч, эцэг эхийн хөгжилд чиглэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Сургуулийн захирал Мөрөн сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг төлөвлөж, 84.1 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан

ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.

- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор "Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн", "Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр", "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал" баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
- БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар "төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар"-ыг 1 дүгээр, "багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар"-ыг 2 дугаар, "цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар"-ыг 3 дугаар, "тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар"-ыг баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
- БШУС-ын 2022 оны А/452 дугаар тушаал "Хувьсах зардлын тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын тухай"
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаал "Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам"
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу сургуулийн захирлын 2020 оны Б/18 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр сард батлуулан, тухайн онд нийт 3 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлж, тайлагнасан боловч дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

Түүнчлэн 2022 онд сургуулийн захирлын тушаалаар шинээр гарсан дүрэм, журмуудын хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсөв санхүүг зарцуулах, түүнд хяналт тавих, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, шинээр гарсан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий зөвлөл, ажлын хэсэг, багуудыг томилж ажиллуулсан байна.

Тус сургууль нь 2022 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулсан байна.

Эдгээр зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналтын 1 ба 2 дугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2019-2021 оны үйл ажиллагаанд нийцлийн аудит хийж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 9 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг 2022 оны 9 сарын 25-ны өдрийн 01/339 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Уг нийцлийн аудитаар Титэм ерөнхий боловсролын сургуулийн спорт зааланд тоног, төхөөрөмж нийлүүлэх ажлын ХӨАОНӨГ/2020010223/07/ тоот гэрээний үүргийг нийлүүлэгч тал хэрэгжүүлээгүй байгаа асуудлаар Хөвсгөл аймгийн БШУГ-т өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Титэм сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа БСШУС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Титэм сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30,521.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	-	74,035.5	74,035.5
Авлага	-	102,086.8	102,086.8
Урьдчилгаа	-	3,480.0	3,480.0
Бараа материал	163,194.6	193,177.8	29,983.1
Үндсэн хөрөнгө	2,863,714.9	2,685,167.5	-178,547.4
Нийт хөрөнгө	3,026,909.5	3,057,947.5	31,037.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,026,909.5	3,057,947.5	31,037.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,026,909.5	3,057,947.5	31,037.9

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 74,035.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 101,570.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 2022 оны 12 дугаар сард цахим дэлгүүрээс худалдан авахаар Ай ти зон ХХК-тай гэрээ байгуулж, төлбөр шилжүүлсэн боловч тайлант онд нийлүүлэгдээгүй суурин компьютерын үнэ 80,640.0 мянган төгрөг, Саммит компьютер технологи ХХК-тай гэрээ байгуулж, төлбөр шилжүүлсэн боловч тайлант онд нийлүүлэгдээгүй зөөврийн компьютерын үнэ 12,255.0 мянган төгрөг, Хөвсгөл булаг ХХК-аас авах авлага 7,940.0 мянган төгрөгийг авлагаар тусгасан нь голлон нөлөөлсөн байна.
3. Урьдчилгаа дансанд Эй Плас Интернэйшнл ХХК-д багшийн хөгжлийг дэмжих модуль сургалтын дараагийн жилд хэрэгжих төлбөр 3,480.0 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.
4. Бараа материал данс өмнөх оноос 29,983.1 мянган төгрөгөөр нэмэгдэхэд БШУС-ын 2022 оны 170 дугаар тушаалын дагуу сургалтын тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлаар 31,539.5 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, Хөвсгөл аймгийн БШУГ-аас 5,997.1 мянган төгрөгийн түрээсийн сурах бичгийг үнэ төлбөргүй хүлээж авсан нь нөлөөлсөн байна.
5. Үндсэн хөрөнгө данс 178,547.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 123,349.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 40651.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, үндсэн хөрөнгийн элэгдэл 285,692.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,607,771.1 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба төсвийн төслийн саналаас 335,701.1 мянган төгрөгөөр бууруулан 2,272,070.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь 2022 оны төсвийн төлөвлөлтийг зардлын эдийн засгийн ангиллаар төлөвлөснийг УИХ-аар үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгохоор баталсантай холбоотой, төсвийн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр удаа дараа нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд: Байгууллагын 2022 оны төсвийн зарлагын сар, улирлын

хуваарийг БШУС-ын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба 2022 оны 10 дугаар сарын 7-ний өдрийн А/258 дугаар тушаал, 12 дугаар сарын 30-ны өдрийн А/392 тоот тушаалаар тус тус өөрчлөлт оруулж, анхны баталсан төсвийг 115,179.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Ингэснээр нийт төсвийн зарлага 2,387,249.5 мянган төгрөг болж, 2,376,247.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэх, 11,001.7 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталжээ.

Орон нутгийн төсвөөс санхүүжих зардлын төлөвлөлт:

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс 346,623.2 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, Мөрөн сумын ЗДТГ-т хүргүүлсэн байна.

Мөрөн сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 02 тоот тогтоолоор төлөвлөсөн дүнг 37,788.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 384,412.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төсөлд зөвхөн байр ашиглалтын тогтмол зардлаар тооцоолсныг байр ашиглалтын үйлчилгээний зардлыг нэмж баталсантай холбоотой.

Мөрөн сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор тус сургуулийн төсөвт тодотгол хийж, 29,289.5 мянган төгрөгөөр бууруулан, 355,122.6 мянган төгрөгөөр баталсан нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, шимтгэлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн А/429 дүгээр захирамжаар төсөвт зохицуулалт хийж, 2,867.6 мянган төгрөгөөр орон нутгийн төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,376,247.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 2,302,212.3 мянган төгрөгийг зарцуулж, 74,035.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 357,990.2 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 1,403.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого 11,001.7 мянган төгрөг төвлөрүүлэхээс 10,825.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн нь 98.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,669,625.0 мянган төгрөг буюу 97.2 хувь байгаа нь бараа үйлчилгээний зардлын төсвийг 70,631.2 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 4,983.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	8,410.50	8,376.53	33.97	99.60
2	80312-Сургалт семинар	4,205.30	720.00	3,485.30	17.12
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	9,672.10	8,945.00	727.10	92.48
4	81801-Үдийн цай хөтөлбөр	193,737.50	188,754.00	4,983.50	97.43
5	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	97,405.00	92,895.00	4,510.00	95.37
6	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	18,923.70	18,923.70	0.00	100.00
7	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,885,781.7	1,844,003.24	41,778.46	97.78
8	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	169,113.70	150,420.35	18,693.35	88.95
	Дүн	2,387,249.50	2,313,037.82	74,211.68	96.89
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	322,372.10	320,969.26	1,402.84	99.56
2	80112-Нийтлэг үйлчилгээ	35,618.10	35,617.94	0.16	100.00
	Дүн	357,990.20	356,587.19	1,403.01	99.61
	Нийт дүн	2,745,239.70	2,669,625.02	75,614.68	97.25

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Титэм сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа гүйцэтгэж, анхан шатын хяналтыг захирал Б.Мядагмаа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Титэм сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,129,136.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 42,582.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 30 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горимыг баримталж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг бууруулахгүй байх зарчмыг баримтлан ажилласан ба сургалт семинарын зардлын гүйцэтгэл 17.1 хувийн гүйцэтгэлтэй, боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардлаас бусад байр ашиглалтын үйлчилгээ, төрийн өмчийн барилгын тогтмол зардал, сургалтын хэвийн үйл ажиллагаа гэх мэт зардлууд 89.0-99.6 хувийн гүйцэтгэлтэй, 6,386.3 мянган төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Титэм сургуулийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд 2022 онд нийт 151 мэдээлэл оруулахаас 1 мэдээлэл хугацаа хоцроож, 145 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна. Байгууллагын 2022 оны батлагдсан төсвийн мэдээлэл нь мэдээлбэл зохих 1 дүгээр сарын 10-ны өдөр дээд шатны төсөв захирагчаас ирээгүй байсан нь хугацаа хоцрох шалтгаан болсон байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Титэм сургуулийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	23.7	1	23.7	100.0
Зөвлөмж	2	15.3	2	15.3	100.0
Нийт дүн	3	39.0	3	39.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн жил дамжин хэрэгжиж байгаа сургалтын үйл ажиллагаа, хувьсах зардлын нөхөн хангалтаар авч байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авч, орлогод авсан эсэх, сургуулийн үйл ажиллагаанд ашиглахаар худалдан авч байгаа сургуулийн удирдлагын цогц системийн ашиглалтад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 122,472.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 122,472.5 мянган төгрөгийн алдааг залруулсан ба төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмж өгөх зөрчил илрээгүй болно.

Аудитаар дараах нягтлан бодох бүртгэлийн залруулгыг хийсэн болно. Үүнд:

- Түрээсийн сурах бичгийн орлогыг аккруэл сууриар бүртгээгүйгээс үр дүнгийн тайланд 11,271.5 мянган төгрөгийн орлого, 516.0 мянган төгрөгийн авлагыг дутуу бүртгэснийг залруулсан.
- Он дамжин хэрэгжих багшийн хөгжлийг дэмжих модуль сургалтын төлбөр 3,480.0 мянган төгрөгийг аккруэл сууриар бүртгээгүй, тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснийг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэж залруулсан.
- Иргэн, аж ахуйн нэгжээс өгсөн 14,310.0 мянган төгрөгийн хандивын орлогыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэснийг хандивын орлого дансанд бүртгэж залруулсан.
- Цахим дэлгүүрээс худалдаж авахаар 12 дугаар сард гэрээ байгуулж, төлбөр төлсөн боловч тайлант онд нийлүүлэгдээгүй 92,895.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг орлогод авсныг авлагаар залруулан бүртгэсэн.

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруу лаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Түрээсийн сурах орлогыг акруэл сууриар бүртгээгүйгээс орлогыг дутуу бүртгэсэн	1	11,271.5	1	11,271.5			1	11271,5				
Он дамжин хэрэгжих багшийн хөгжлийг дэмжих модуль сургалтыг акруэл сууриар бүртгээгүй, тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрсөн	1	3,480.0			1	3,480.0	1	3480.0				
Түрээсийн сурах орлогыг акруэл сууриар бүртгээгүйгээс авлагыг бүртгээгүй	1	516.0	1	516.0			1	516.0				
Биетээр байхгүй компьютер тоног төхөөрөмжийг орлогод авсан	1	92,895.0			1	92,895.0	1	92895.0				
Иргэн, аж ахуйн нэгжээс өгсөн хандивын орлогыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн	1	14,310.0			1	14,310.0	1	14310.0				
Дүн	5	122,472.5	2	11,787.5	3	110,685.0	5	122,472.5				